



“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Цэцээгүн 206 тоот
Утас: (+976) 990965848 (+976) 70001981
И-мэйл: csi_sevjee@yahoo.com

Г “Талх Чихэр” ХК-ийн ТУЗ болон Г
Гүйцэтгэх захирал Л.Баттөр
танаа

2024.03.25 № 23/134

Танаа _____-ны № _____-Т

Хараат бус аудиторын тайлан

Дүгнэлт:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу “Талх Чихэр” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд гэрээний дагуу аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Талх Чихэр” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд:

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна.

Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна

Бусад мэдээлэл:

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ.

Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.

Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага:

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтээр өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэж итгэж байгаач АОУС-ын дагуу хийж гүйцэтгэж байгаа аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш.

Бусад:

Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн

ЗАХИРАЛ  М.СЭВЖИДМАА



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Талх Чихэр ХК
(Байгууллагын нэр)

СТА/2023/137

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31	Тайлант оноос /+өссөн/ /-буурсан/ үзүүлэлт
А.ХӨРӨНГӨ			
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	189,558,973.15	97,531,269.70	(92,027,703.45)
Дансны авлага	4,775,355,485.66	6,310,345,571.31	1,534,990,085.65
Татвар, НДШ-ийн авлага	-	10,619,437.76	10,619,437.76
Бусад авлага	168,666,943.30	-	(168,666,943.30)
Бараа материал	3,340,705,928.27	7,696,962,215.16	4,356,256,286.89
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	9,819,277,157.75	13,061,586,532.24	3,242,309,374.49
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,293,564,488.13	27,177,045,026.17	8,883,480,538.04
2. Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	61,000,601,977.57	60,612,664,624.43	(387,937,353.14)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	61,000,601,977.57	60,612,664,624.43	(387,937,353.14)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	79,294,166,465.70	87,789,709,650.60	8,495,543,184.90
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
3. Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	9,090,896,042.90	9,550,822,425.10	459,926,382.20
Цалингийн өглөг	602,573,452.40	1,122,806,749.00	520,233,296.60
Татварын өр	509,962,273.23	1,035,145,497.22	525,183,223.99
НДШ-ийн өглөг	20,162,902.08	-	(20,162,902.08)
Ногдол ашгийн өглөг	1,623,430,562.64	1,975,851,098.53	352,420,535.89
Бусад богино хугацаат өр төлбөр	549,627,319.23	753,078,108.14	203,450,788.91
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,396,652,552.48	14,437,703,877.99	2,041,051,325.51
4. Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	2,248,110,372.50	1,069,701,180.77	(1,178,409,191.73)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,077,599,596.00	1,899,190,404.27	(1,178,409,191.73)
Өр төлбөрийн нийт дүн	15,474,252,148.48	16,336,894,282.26	862,642,133.78
5. Эзэмшигчийн өмч			
- хувийн	102,370,300.00	102,370,300.00	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,340,772,092.32	23,340,772,092.32	-
Хуримтлагдсан ашиг	40,376,771,924.90	48,009,672,976.02	7,632,901,051.12
Эзэмшигчийн өмчийн дүн	63,819,914,317.22	71,452,815,368.34	7,632,901,051.12
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	79,294,166,465.70	87,789,709,650.60	8,495,543,184.90
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН			
Цэвэр борлуулалт	100,857,714,535.23	122,329,182,510.74	21,471,467,975.51
Борлуулалтын өртөг	68,945,160,144.20	85,702,890,758.72	16,757,730,614.52
Нийт ашиг (алдагдал)	31,912,554,391.03	36,626,291,752.02	4,713,737,360.99
Борлуулалт, маркетингийн зардал	697,290,174.39	-	(697,290,174.39)
Ерөнхий ба удирдлагын зардал	13,750,289,028.39	26,353,223,201.66	12,602,934,173.27
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	9,137,622,798.23	-	(9,137,622,798.23)
Бусад ашиг (алдагдал)	(744,983,126.12)	(613,604,311.65)	131,378,814.47
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	7,582,369,263.90	9,659,464,238.71	2,077,094,974.81
Орлогын албан татварын зардал	1,181,838,097.51	1,668,267,137.59	486,429,040.08
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	6,400,531,166.39	7,991,197,101.12	1,590,665,934.73
Цэвэр ашиг (алдагдал)	6,400,531,166.39	7,991,197,101.12	1,590,665,934.73
Орлогын нийт дүн	6,400,531,166.39	7,991,197,101.12	1,590,665,934.73
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	6,252.33	7,806.17	1,553.84

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмч	102,370,300.00	102,370,300.00	-
Халаасны хувьцаа	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,340,772,092.32	23,340,772,092.32	-
Хуримтлагдсан ашиг /- алдагдал/	40,376,771,924.90	48,009,672,976.02	7,632,901,051.12
Нийт дүн	63,819,914,317.22	71,452,815,368.34	7,632,901,051.12

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	102,284,888,846.9	139,311,306,470.8	37,026,417,623.96
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	102,284,888,846.9	139,311,306,470.8	37,026,417,623.96
Мөнгөн зарлагын дүн (-)	100,313,342,463.2	132,354,355,623.1	32,041,013,159.88
Ажиллагчдад төлсөн	10,157,262,732.8	16,047,177,007.8	5,889,914,275.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,633,913,722.0	5,372,550,036.5	1,738,636,314.51
Бараа материал худалдан авахад төлсөн	78,882,920,731.2	106,675,671,672.8	27,792,750,941.55
Хүүний төлбөрт төлсөн	200,905,023.6	128,530,355.5	(72,374,668.11)
Татварын байгууллагад төлсөн	1,119,507,319.5	1,804,447,620.0	684,940,300.50
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	-
Бусад мөнгөн зарлага	6,318,832,934.1	2,325,978,930.5	(3,992,854,003.57)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,971,546,383.7	6,956,950,847.7	4,985,404,464.08

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	-	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	5,882,022,646.5	5,882,022,646.50
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	5,882,022,646.5	5,882,022,646.50
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(5,882,022,646.5)	(5,882,022,646.50)

3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	3,000,000,000.0	1,485,620,209.6	(1,514,379,790.40)
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,000,000,000.0	1,465,345,709.6	(1,534,654,290.40)
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	20,274,500.0	20,274,500.00
Мөнгөн зарлагын дүн (-)	5,597,923,228.3	2,649,042,864.0	(2,948,880,364.27)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,153,169,589.0	2,643,754,901.3	(2,509,414,687.67)
Төлсөн ногдол ашиг	11,519,835.3	5,287,962.7	(6,231,872.60)
	433,233,804.0	-	(433,233,804.00)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,597,923,228.3)	(1,163,422,654.4)	1,434,500,573.87
Валютын ханшийн зөрүү	(9,388,743.8)	(3,533,250.3)	5,855,493.49
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(635,765,588.4)	(92,027,703.5)	543,737,884.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	825,324,561.5	189,558,973.1	(635,765,588.39)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,558,973.1	97,531,269.7	(92,027,703.45)

АУДИТОР *С. Доржиев* Р.ДОЛЖИНСҮРЭН

